

2021 оны 4 дугаар улиралын санхүүгийн

үйл ажиллагааны товч тайлан

Чойбалсан хот

2021.12.31

“Дорнод Авто зам” Хувьцаат компани нь аймгийнхаа нутаг дэвсгэрт байгаа улсын чанартай асфальт бетон хучилттай 160 км зам, ердийн хөрсөн 819,92 км зам, хайрган хучилттай 291,17 км зам, сайжруулсан хөрсөн 13,66 км зам нийт 1284,75км авто замын арчлалтын хариуцан гүйцэтгэдэг бөгөөд эдгээр замууд нь ОХУ, БНХАУ-тай 7 чиглэлээр холбогддог, улс хоорондын авто замын тээвэрт чухал үүрэг ач холбогдолтой. Халхгол, Хэрлэнгийн доод дээд 2 гүүр, Улзын голын нийт 4 бетон хийц бүхий 864 у/м гүүрүүдийн арчлалт хамгаалалтын ажлыг 4 гүүр хамгаалагч хариуцан ажиллаж байна.

Манай компани нь 2021 оны 4р байдлаар 1174,2 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 1148,0 сая төгрөгийг үйл ажиллагаандaa зарцуулсан. 2021 онд Зам, Тээврийн Хөгжлийн Яамтай хийсэн гэрээний дагуу улсын чанартай зам засвар арчлалтын болон бусад гэрээний дагуу ажлууд хийж гүйцэтгэв. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, ажлыг гэрээт хугацаандаа бүрэн хийж гүйцэтгэх, техникийн бүрэн бүтэн байдал, сэлбэг шатахуун, материалыаар тасралтгүй ханганд ажиллах, ажлыг жигд явуулахын тулд график төлөвлөгөө гарган, цаг тухайд нь гүйцэтгэхээр төлөвлөн ажиллахыг хичээсэн. Улиралын чанартай ажил гүйцэтгэхэд хөл хороо тогтоогдсон, ажиллах хүчиний хомсдолтой, ажилчидын дунд цар тахлын тархалт өндөр байсан зэрэг нь үйл ажиллагаа жигд тогтвортой явуулахад бэрхшээл тулгарч, түлш шатахууны үнэ өсч, хил гааль хаагдсанаас шалтгаалан материалын үнэ өссөн, авто зам, барилгын гол түүхий эд болох цемент, асфальт, бетон зуурмагийн нөөц ховордох, бэлтгэн нийлүүлэгчдийн гэрээ тасалдах зэрэг олон үр дагаварууд гарч ажил явуулахад хүндрэл бэрхшээл их байлаа. Мөн авто зам, замын байгууламжийн урсгал засвар, арчлалтын ажлыг холбогдох норм, дүрэм, стандарт, журмыг баримтлан, гэрээнд болон график төлөвлөгөөнд заасан хугацаа, хөрөнгийн хэмжээнд багтаан техникийн шаардлагын дагуу гүйцэтгэж, авто зам, замын байгууламжийн байнгын бэлэн байдлыг ханганд ажиллахад анхаарч ажилласан.

Компани дээрхи ажлуудыг хийж гүйцэтгэхдээ 29 ажиллагадтайгаар зам засвар арчлалтын ажилд ажиллаж, цалингийн зардалд 229,5 сая төгрөг, НДШимтгэлд 34,6 сая төгрөг төлж, Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа Цар тахлын үе дэх аж ахуйн нэгжийг дэмжих ажлын хүрээнд 4,8 сая төгрөгийн НДШимтгэлийн хөнгөлөлт эдлэж, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаагаа хэвийн хэмжээнд байлгах зарчим баримтлан ажиллаж байна. Мөн материал түүхий эд худалдан авах, сэлбэг хэрэгсэл болон шатахууны зэрэг шууд үйлдвэрлэлийн зардалд 540,9 гаруй сая төгрөгийг зарцуулав. Татвар шимтгэлд 150,2 сая төгрөгийн татвар төлөлтийг аймаг орон нутгийн татварт төвлөрүүлэн ажиллалаа. Цар тахлын үеэр тавигдсан хөл хорооны үед үйл ажиллагаагаа явуулахад нилээд хүндрэл үүсч байсан боловч ажиллагадынхаа цалин, холбогдох үйлдвэрлэлийн зардлуудаа тасалдуулахгүй, ажлын байрыг хадгалан үлдэхийн тулд хүчин чармайлт гарган ажиллалаа.

Нягтан бодох бүртгэл хөтлөлтийг НББОУС-ын дагуу хөтлөн, баланс, орлого үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, бусад тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланг бэлтгэн компанийн удирдлагыг санхүүгийн иж бүрэн мэдээлэлээр ханганд ажиллаж байна.

Тайлан бичсэн:

“Дорнод Авто зам” Хувьцаат компанийн

Нягтан бодогч

Ц.ОТГОН